

**БАТЛАВ:**  
**“БАРИЛГА ЭМ ЭН” ХХК-ИЙН**  
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

.....  
**Д.ЦОЛМОНГЭРЭЛ**

INTERNATIONAL CONSTRUCTION FAIR  
**BARILGA**  
**EXPO**  
**2019**

**БАТЛАВ:**  
**“.....”ХХК-ИЙН**  
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

.....  
/...../

**“БАРИЛГА ЭКСПО-2019” ОРОН СУУЦ, ХАУС ДИЗАЙНЫ**  
**ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАЛБАЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ**

2019 оны .... дүгээр сарын .....-ны өдөр №..... Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас 6030548 тоот регистрийн дугаар, 9011582029 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй **“БАРИЛГА ЭМ ЭН” ХХК** /цаашид *“түрээслүүлэгч буюу зохион байгуулагч”* гэх/ түүнийг төлөөлж Хуулийн зөвлөх Г.Төмөрсүх,

Нөгөө талаас ..... тоот регистрийн дугаар, ..... тоот улсын бүртгэлийн дугаартай *“.....” ХХК* /цаашид *“Түрээслэгч буюу оролцогч”* гэх/ түүнийг төлөөлж ..... албан тушаалтай ..... нар /хамтад нь **“Талууд”** гэх/ харилцан тохиролцож дараах нөхцлөөр байгуулав.

**Нэг. Үндсэн нөхцөл**

- 1.1 Энэхүү гэрээ нь оролцогчийн орон сууц, хаус дизайныг олон нийтэд танилцуулах зорилгоор үзэсгэлэн яармагийн зохион байгуулагч, оролцогч талуудын хамтын ажиллагааг зохицуулна.
- 1.2 Түрээслэгч нь **2019 оны 05 дугаар сарын 03-наас 05 дугаар сарын 05-ны** хооронд **“БАРИЛГА ЭКСПО-2019”** орон сууц, хаус дизайны үзэсгэлэн яармагт ..... дугаартай ..... м<sup>2</sup> талбай бүхий стендыг өнгө үзэмжтэй тохижуулж оролцоно.
- 1.3 Үзэсгэлэн зохион байгуулагч буюу түрээслүүлэгч тал болон үзэсгэлэнд оролцогч буюу түрээслэгч талууд нь энэхүү гэрээг нэг бүрчлэн буюу зүйл заалт тус бүрийг уншиж танилцаж, зөвшөөрч гэрээг байгуулсан болно.
- 1.4 Түрээслэгч нь түрээсийн талбай дахь стэндийг цоолох, будах, наалт наах, гэмтээх зэргийг хатуу хориглох бөгөөд анх хүлээж авсан байдлаар нь буцааж хүлээлгэж өгнө.

**Хоёр. Түрээслүүлэгч талын эрх, үүрэг**

- 2.1 Түрээслүүлэгч буюу зохион байгуулагч нь үзэсгэлэнгийн стэндийг **2019 оны 05 сарын 01-нд** талбай түрээслэгч талд хүлээлгэн өгнө.
- 2.2 Түрээслүүлэгч буюу зохион байгуулагч тал нь **2019 оны 05 дугаар сарын 03-наас 05 дугаар сарын 05-ны** өдрийн оройн **18:00** цагаас маргааш өглөөний **09:30** цаг хүртэлх хугацаанд талбайд буй бараа материалын бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэгтэй.
- 2.3 Түрээслүүлэгч буюу зохион байгуулагч нь талбайн түрээслэгчийг үзэсгэлэнгийн өдрүүдэд цахилгаан, гэрэлтүүлгээр хангах үүрэгтэй.
- 2.4 Санаатай болон санамсаргүй байдлаар өндөр хүчдэлийн цахилгаан хэрэгсэл холбож, бусад талбай түрээслэгч болон мишээл экспогийн танхимд хохирол учруулбал учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

**Гурав. Түрээслэгч талын эрх, үүрэг**

- 3.1 Талбай түрээслэгч нь үзэсгэлэнгийн танхимд ажиллахдаа цахилгаан, гал, ус, харуул хамгаалалт зэрэг аюулгүй байдлыг хангаж, үзэсгэлэнгийн өдрүүдэд гэрээний үүргээ биелүүлэх үүрэгтэй.
- 3.2 Үзэсгэлэн нээгдэх өдөр буюу **2019 оны 05 дугаар сарын 03-ны 10:00** цагт олон нийтэд үйлчлэхэд бэлэн болсон байх үүрэгтэй.
- 3.3 Талбай түрээслэгч нь үзэсгэлэнгийн хаалтын өдөр буюу **2019 оны 05 дугаар сарын 05-ны** өдрөөс хойш 1 өдрийн дотор талбайг чөлөөлж, талбайг бүрэн бүтэн байдлаар нь зохион байгуулагчид хүлээлгэж өгөх үүрэгтэй.
- 3.4 Түрээслэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүйгээс бусдад болон зохион байгуулагчид хохирол учирсан тохиолдолд хохирлыг төлөх үүрэгтэй.
- 3.5 Түрээслэгч буюу үзэсгэлэнд оролцогч тал нь үзэсгэлэнгийн өдрүүдэд өглөөний **09:30-18:00** цагийн хооронд талбайн байрласан эд зүйлс болон талбайн бүрэн байдлыг хариуцах үүрэгтэй.
- 3.6 Үзэсгэлэнгийн өдрүүдэд гэрээний 3.5-д заасан цагаас өмнө буюу 18.00 цагаас өмнө талбайг орхин явснаас үүссэн аливаа хохирол, хариуцлагыг түрээслүүлэгч тал хүлээхгүй.
- 3.7 Түрээслэгч нь экспод зориулан хэвлэн гаргаж, үнэ төлбөргүй тараадаг “Барилга Экспо” сэтгүүлд байрших хүснэгтэн мэдээллийг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө түрээслүүлэгчид ирүүлнэ.
- 3.8 Түрээслэгч нь гэрээний 3.7-д заасан мэдээллийг 2019.04.15-наас хойш илгээсэн тохиолдолд тус мэдээлэл нь Барилга экспо сэтгүүлд нийтлэгдэх боломжгүй ба хугацаа хожимдож илгээсэн мэдээллийг түрээслүүлэгч тал нийтлэх үүрэг хүлээхгүй.
- 3.9 Түрээслэгч нь үзэсгэлэнд оролцохдоо өөрийн компанийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчилах, танилцуулах, худалдаалах бөгөөд өөр бусад байгууллагын бараа, бүтээгдэхүүнийг стэндэнд байршуулах, танилцуулах, худалдаалахыг хориглоно. Энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн торгуулийг үл маргах журмаар түрээслүүлэгч талд төлнө.
- 3.10 Үзэсгэлэн дууссанаас хойш буюу 2019 оны 05 сарын 06-ны 09:00-13:00 цагийн хооронд түрээсийн талбайг бүрэн чөлөөлсөн байна.

#### **Дөрөв. Төлбөр тооцоо**

- 4.1 Үзэсгэлэнд талбай түрээслэн оролцох нийт төлбөр нь ..... /...../ төгрөг болно.
- 4.2 Түрээслэгч нь гэрээ байгуулахад 50% буюу ..... төгрөгийг төлж, үлдэгдэл төлбөр болох ..... төгрөгийг **2019 оны 04** дүгээр сарын **01**-ний дотор түрээслэгч талд бүрэн төлж барагдуулахаар харилцан тохиролцов.
- 4.3 Талбай түрээслэгч тал нь **2019 оны 04** дүгээр сарын **10**-наас өмнө үзэсгэлэнд оролцох боломжгүй тухайгаа зохион байгуулагчид албан бичгээр мэдэгдсэн тохиолдолд түрээсийн төлбөрийг буцааж олгоно. **2019 оны 04** дүгээр сарын **10**-наас хойш үзэсгэлэнд оролцох боломжгүйгээ мэдэгдсэн, талбайгаа тохижуулан үзэсгэлэнд оролцоогүй, гэрээг цуцлах санал гаргасан тохиолдолд түрээсийн төлбөрийг түрээслэгчид буцаан олгохгүй.
- 4.4 Төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд төлөөгүй хоног тутамд 0.5 хувийн алданги тооцохоор тохиролцов.

#### **Тав. Үзэсгэлэнд оролцох**

- 5.1 “БАРИЛГА ЭКСПО-2019” үзэсгэлэн нь 2019 оны 05 дугаар сарын 03-наас 05-ны өдрүүдэд өглөөний 09.00 цагаас оройн 18.00 цаг хүртэл Мишээл Экспо төвд зохион байгуулагдана.

*Түрээслүүлэгч:..... Хуудсыг баталгаажуулав: Түрээслэгч: .....*

- 5.2 Үзэсгэлэнд оролцогч байгууллагууд нь 2019 оны 04 дүгээр сарын 01-ний дотор зохион байгуулагчтай холбогдох төлбөр тооцоог дуусгавар болгосон байна.
- 5.3 Гэрээнд заасан төлбөрийг төлсөн тохиолдолд зохион байгуулах комиссын зүгээс оролцогчдод үзэсгэлэнгийн талбайг засаж тохижуулах зөвшөөрөл олгох ба үзэсгэлэнгийн талбайд нэвтрэх мандат олгоно.
- 5.4 Талбайн хуваарилалтын зургийг Мишээл экспо төвийн үүдэнд байрлуулсан байх тул талбай засахаар очихдоо талбайн зурагтай харьцуулан баталгаажуулсны дараа засалтаа хийнэ.
- 5.5 Оролцогч байгууллага нь өөрийн үйлдвэрийн болон гадны албан ёсны зөвшөөрөлтэй нэрийн бараа бүтээгдэхүүнээр оролцож, сурталчилах ба өвөрмөц байдлаар эзэмшлийн талбайгаа засч тохижуулсан байна.
- 5.6 Түрээслэгч нь үзэсгэлэнгийн стэнд засалтыг 2019.05.01-ны Лхагва гарагаас эхэлж 2019.05.03-ны Пүрэв гарагийн 18.00 цагаас өмнө дуусгавар болгосон байна.
- 5.7 Түрээслэгч нь үзэсгэлэнгийн танхимын дотор болон гадна талбайн гэрэлтүүлэг, зам талбайг хэвийн байдлыг гэмтээхгүй, стэндийг цоолж будахгүйгээр талбайн засалтаа хийнэ.
- 5.8 Үзэсгэлэнгийн гэрэл, цахилгаантай холбоотой асуудлаар “МИШЭЭЛ ЭКСПО” төвийн зохион байгуулагчтай /...../ холбогдоно.
- 5.9 Ачаа бараа ачиж буулгахдаа үзэсгэлэнгийн байрны гадна хаалгыг таглаж зогсохгүй байх, ачааг эзэнгүй орхихгүй байх.
- 5.10 Үзэсгэлэнгийн нээлтийн үеэр оролцогч байгууллага нь талбай дээрээ ажиллах нэг хүнийг үлдээж компаний захирал болон төлөөллүүд нээлтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцоно. (Нээлтийн арга хэмжээнд шийдвэр гаргах түвшний албан тушаалтан түүний төлөөлөл заавал оролцуулна)
- 5.11 Үзэсгэлэнгийн өдрүүдийн өглөө бүр 09.00 цагт үзэсгэлэнд оролцогчдыг зөвхөн энгэрийн тэмдэг буюу мандатаар зааланд нэвтрүүлэх тул эхний хүн цагтаа ирж стэндээ нээсэн байна.
- 5.12 Үзэсгэлэн дуусах өдөр оролцогчид хариуцсан талбайн хог хаягдлаа бүрэн гүйцэт цэвэрлэж байгууллагынхаа нэр хүндийг бодолцон соёлтой оролцоно.
- 5.13 Үзэсгэлэн дууссаны дараа хог хаягдлыг түрээслэгч тал хариуцан авч явна. Мишээл экспогийн гаднах хогийн цэгт овор ихтэй хог хаягдал орхихыг хориглоно.
- 5.14 Үзэсгэлэнд оролцогчид нь өөрсдийн бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 5.15 Оролцогч байгууллагууд нь зохион байгуулах комиссын зүгээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж, хамтран ажиллана.
- 5.16 Түрээслэгч нь түрээсийн төлбөрийг бүрэн буюу **100%** төлөөгүй тохиолдолд түрээслүүлэгч тал нь түрээслэгчийг үзэсгэлэнд оролцуулахгүй.
- 5.17 Түрээслэгч нь түрээсийн гэрээг цуцлах санал гаргах, үзэсгэлэнд оролцох боломжгүйгээ түрээслүүлэгч талд мэдэгдэх, үзэсгэлэнд оролцоогүй тохиолдолд зохион байгуулагч тал нь үзэсгэлэнгийн төлбөрийг буцаан олгохгүй. Мөн үзэсгэлэнгийн талбайд хэсэгчилж буюу хувааж орсон тохиолдолд үлдсэн талбайн түрээсийн төлбөрийг түрээслүүлэгч тал нь буцаан олгохгүй.

#### **Тав. Бусад**

- 6.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа саналын зөрүү, маргааныг талууд харилцан зөвшилцөх аргаар шийдвэрлэхийг урьтал болгоно. Хэрэв зөвшилцөлд хүрэхгүй бол хуулийн байгууллагад хандана.
- 6.2. Оролцогч стэндийг зохион байгуулагчийн зөвшөөрөлгүй бусдад дамжуулан түрээслэвэл, эсвэл төлбөрөө хугацаандаа төлөөгүй бол гэрээг түрээслүүлэгч тал дангаар цуцалж, өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.
- 6.3. Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болж, гэрээг цуцалсанаар эсвэл гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.

*Түрээслүүлэгч:..... Хуудсыг баталгаажуулав: Түрээслэгч: .....*

6.4. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд нэг нэг хувийг хадгална.

<p><b>Стэндний дугаар:</b> .....</p> <p><b>Захиалсан талбайн хэмжээ:</b> .....</p> <p><b>1м<sup>2</sup>-ын төлбөр:</b> .....</p> <p><b>Нийт төлбөр:</b> .....</p> <p><b>Данс: ХААН БАНК 5175011074 /төгрөгийн/</b></p> <p><b>Нэр: “БАРИЛГА ЭМ ЭН” ХХК</b></p>	<p>1. <b>Үзэсгэлэнгийн мэдээллийг хаанаас авсан бэ?</b>  <b>А. Сайт, Б. И-мэйл, В. Аман яриа,</b>  <b>Г. Зар сурталчилгаа Д. Бусад.....</b></p> <p>2. <b>Үзэсгэлэнд хэд дэх удаагаа оролцож байна вэ?</b>  <b>А. Анх удаа Б. .... удаа</b></p> <p>3. <b>Barilga.MN сайтын гишүүн эсэх?</b>  <b>Тийм Үгүй</b></p> <p>4. <b>Байгууллагын хаяг хийлгэх үү?</b>  <b>Тийм Үгүй</b></p> <p>5. <b>Стэндний хаяг хийлгэх нэрийг доор бичнэ ҮҮ.</b>          .....</p>
---	---

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

**Түрээслүүлэгч буюу зохион байгуулагч талыг төлөөлж:**

**Түрээслэгч буюу оролцогч талыг төлөөлж:**

Албан тушаал: Хуулийн зөвлөх  
 Г.Төмөрсүх  
 Гарын үсэг: \_\_\_\_\_  
 Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
 6-р хороо, “Барилга Эм Эн” ХХК-ийн Barilga.MN  
 оффис, 5 давхар  
 Утас: 7711-3333, 9900-0981, 9990-7814, 9990-7816  
 Факс: 7711-3333  
 Вэб хаяг: [www.barilgaexpo.mn](http://www.barilgaexpo.mn), [www.barilga.mn](http://www.barilga.mn)  
 Цахим шуудан: [info@barilga.mn](mailto:info@barilga.mn),  
[tsolmontuya@barilga.mn](mailto:tsolmontuya@barilga.mn)  
 Харилцах банкны нэр: ХААН БАНК  
 Дансны дугаар: 5175011074  
 Хүлээн авагч: “Барилга Эм Эн” ХХК

Албан тушаал:  
 .....  
 Гарын үсэг: \_\_\_\_\_  
 Хаяг: Улаанбаатар хот, .....  
 .....  
 .....  
 Утас:  
 Факс:  
 Вэб хаяг:  
 Цахим шуудан:

*Түрээслүүлэгч:..... Хуудсыг баталгаажуулав: Түрээслэгч: .....*